



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 205

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Монголын үнэт цаасны клирингийн төв" ХХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 19 нэрийн нийт 61,002,627.70 (жаран нэгэн сая хоёр мянга зургаан зуун хорин долоон төгрөг далан мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 18,468,232.31 (арван найман сая дөрвөн зуун жаран найман мянга хоёр зуун гучин хоёр төгрөг гучин нэгэн мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2."Монголын үнэт цаасны клирингийн төв" ХХК-ийн гүйцэтгэх захирал О.Эрдэнэгэрэлд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн
2022.05.13 дугаар тогтоолын хавсралт

"Монголын үнэт цаасны клирингийн төв" ХХК -ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, үлдэгдэл
өртөггүй, ашиглах хугацааг сунгаж үнийг шинэчлэн тогтоох хөрөнгийн жагсаалт

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтад орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт балансын үнэ /хуримтлагдсан элэгдэл/ (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)			Цаашид ашиглах хугацаа (жилээр)
						Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт үнэ (төгрөг)	
1	Dell server R 720	2015.10.08	8,074,000.00	2	16,148,000.00	2,422,200.00	2	4,844,400.00	2
2	Dell server R 220	2015.10.08	3,491,000.00	4	13,964,000.00	1,047,300.00	4	4,189,200.00	2
3	Dell server R 220	2015.10.08	3,881,000.00	1	3,881,000.00	1,164,300.00	1	1,164,300.00	2
4	Галт хана /Firewall/	2015.10.09	10,870,200.00	1	10,870,200.00	3,261,060.00	1	3,261,060.00	2
5	Managed switch	2015.10.09	2,692,800.00	1	2,692,800.00	807,840.00	1	807,840.00	1
6	Unmanaged switch	2015.10.09	228,360.00	2	456,720.00	68,508.00	2	137,016.00	1
7	Тог баригч	2015.10.09	1,934,350.00	2	3,868,700.00	580,305.00	2	1,160,610.00	1
8	Тог баригч /6KVA/	2015.12.10	3,916,993.85	2	7,833,987.70	1,175,098.16	2	2,350,196.31	1
9	Принтер 3 үйлдэлтэй	2016.04.26	450,000.00	1	450,000.00	135,000.00	1	135,000.00	2
10	Ширээ 120	2011.06.06	147,155.00	1	147,155.00	73,577.50	1	73,577.50	5
12	Шаф гүйдэг хаалгатай намхан	2008.12.18	571,410.00	1	571,410.00	285,705.00	1	285,705.00	5

13	Шүүгээ /тумбочка/ LGOB-H3	2011.06.06	118,655.00	1	118,655.00	59,327.50	1	59,327.50	5
	Нийт дүн			19	61,002,627.70 (жаран нэгэн сая хоёр мянга зургаан зуун хорин долоон төгрөг далан мөнгө)		19	18,468,232.31 (арван найман сая дөрвөн зуун жаран найман мянга хоёр зуун гучин хоёр төгрөг гучин нэгэн мөнгө)	